

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл, зарим онцлох заалтууд

Холбоо барих:

Серги Кобахизде

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Ахлах менежер
Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Өлзийбаярын Намуунбаяр

Хуулийн зөвлөх
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
namuunbayar.ulziibayar@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
605 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn



Хураангуй

2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах, батлах асуудал хөндөгдөөд нэлээдгүй хугацаа өнгөрчээ. Хөрөнгө оруулалтын тухай хууль нь Монгол улсад хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулагчдад олгох баталгаа, дэмжлэг, урамшуулал, хөрөнгө оруулагчийн эрх зэрэг асуудлыг зохицуулдаг тул хөрөнгө оруулагчдын хувьд анхаарч авч үздэг гол хууль байдаг. Иймд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд (“**Хуулийн төсөл**”)-д заасан онцлох зохицуулалтыг үүгээр танилцуулж байна.



Бизнест хамааралтай голлох өөрчлөлтүүд

1. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хуулийн төсөл нь 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуулиас нэршлийн хувьд ялгаатай буюу “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” болж өөрчлөгдөхөөр болж байна. Түүнчлэн, Хуулийн төслийн дийлэнх заалт гадаадын хөрөнгө оруулагчдад хамааралтай байх боловч татварын урамшууллын зохицуулалт нь дотоодын хөрөнгө оруулагчдад мөн хамааралтай байхаар заажээ. Хуулийн төсөл нь нийт 6 бүлэг 26 зүйлтэй бөгөөд бүлэг тус бүрт дараах харилцааг зохицуулжээ.

1-р бүлэг	Нийтлэг үндэслэл
2-р бүлэг	Хөрөнгө оруулалтын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг
3-р бүлэг	Хөрөнгө оруулалтын хамгаалалт
4-р бүлэг	Хөрөнгө оруулалтын бүртгэл, урамшуулал
5-р бүлэг	Хөрөнгө оруулагчийн гомдол, хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх ажиллагаа
6-р бүлэг	Бусад

2. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хуулийн төсөлд заасан гадаадын хөрөнгө оруулалт ба гадаадын хөрөнгө оруулагчийн тодорхойлолт нь одоогийн хуулиас нэлээд өргөн хүрээнд томъёологдсон байна.

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Бид энэхүү нийтлэлд үндэслэн хийсэн аливаа үйлдэл, эс үйлдэхүйн хувьд хариуцлага хүлээхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.



PwC Legal

A multidisciplinary law firm



Бизнест хамааралтай голлох өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

Тодруулбал, одоогийн хуулиар хөрөнгө оруулалт гэдгийг МУ-д үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн **хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан хөрөнгө** байхыг заасан байдаг. Харин Хуулийн төсөлд хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагчийг нэлээд өргөн хүрээнд буюу дараах байдлаар МУ-ын нутаг дэвгэрт хөрөнгө оруулснаар нь тодорхойлохоор заажээ. Үүнд:

- | | | |
|--|--|--|
| ◆ Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулах | ◆ Хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах | ◆ Үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулах |
| ◆ Төр, хувийн хэвшлийн түншлэл, бүтээгдэхүүн хуваах гэрээ, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах | ◆ Компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх | ◆ Оюуны өмчийн эрхийг холбогдох хуульд заасны дагуу эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө оруулах |
| ◆ Хуулийн этгээдийн хувьцаанд хөрвөх зээл олгох | ◆ Санхүүгийн түрээс (лизинг)-ийн болон франчайзийн хэлбэрээр хөрөнгө оруулах | ◆ Бие даан эсвэл бусад хөрөнгө оруулагчтай хамтран шинэ төсөл хэрэгжүүлэх |
- ◆ Хөрөнгө оруулалтын тодорхойлолтод хамаарах хуулиар хориглоогүй хөрөнгө оруулалтын бусад хэлбэр

Гадаад хөрөнгө оруулалттай хуулийн этгээд

Гадаадын хөрөнгө оруулагчийн Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд заавал оруулах хөрөнгийн доод хэмжээг салбар харгалзахгүйгээр 100,000 ам.доллар гэж заасан одоогийн хуулийн шаардлагыг хассан. Харин Засгийн газраас хөрөнгө оруулалт хийх салбараас шалтгаалан хөрөнгө оруулалтын доод хэмжээг ялгамжтай тогтоохоор Хуулийн төсөлд тусгасан байна. Мөн гадаадын хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь холбогдох төрийн байгууллагаас гаргасан шаардлагад нийцүүлэн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллээ тайлагнах, бүртгүүлэх нэмэлт үүргийг Хуулийн төсөлд оруулсан нь өмнө нь байгаагүй шинэ шаардлагыг болсон байна.

3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРАМШУУЛАЛ

Татварын бус урамшууллын хувьд зарчмын өөрчлөлт гараагүй байна. Харин татварын урамшууллын үндсэн хэлбэрүүд 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасантай үндсэндээ төстэй харагдах боловч зарчмын хэд хэдэн өөрчлөлтүүд орсон байна. Татварын урамшуулал нь татварын орчныг тогтворжуулах гэсэн хүрээнд хязгаарлагдсан. Татварын орчныг тогтворжуулах гэдэгт татварын хувь, хэмжээ, элэгдэл, хорогдол тооцох хугацаа, татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох хугацааг хамааруулахаар хязгаарласан. Тодорхой нэр заасан техник, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувь, хэмжээгээр ногдуулах одоогийн зохицуулалтыг Хуулийн төсөл, болон дагаж өөрчлөгдөх хуулиудад тусгаагүй байна.



Татварын урамшууллын хэлбэр

- Тогтворжуулах гэрчилгээ
- Хөрөнгө оруулалтын гэрээ
- Гаалийн татвараас чөлөөлөх



Татварын бус урамшууллын хэлбэр

- Виз, оршин суух зөвшөөрөл
- Гадаад ажилтны төлбөр, зөвшөөрөл гэх мэт



PwC Legal
A multidisciplinary law firm

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Лерал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Бид энэхүү нийтлэлд үндэслэн хийсэн аливаа үйлдэл, эс үйлдэхүйн хувьд хариуцлага хүлээхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Лерал ХХН-ийг илэрхийлнэ.



Бизнест хамааралтай голлох өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

Тогтворжуулах гэрчилгээ

Тогтворжуулах гэрчилгээтэй холбоотой дараах зохицуулалтууд Хуулийн төсөлд тусгажээ. Тодруулбал:

- ♦ Тогтворжуулах гэрчилгээгээр зөвхөн татварын хувь хэмжээг тогтворжуулах зохицуулалттай байсныг татварын орчныг бүхэлд нь тогтворжуулахаар өргөтгөн зохицуулсан.
- ♦ Монгол улсын хуулийн этгээд, хувь хүн тогтворжуулах гэрчилгээг авч болохоор заасан.
- ♦ 30 жил хүртэлх хугацаагаар олгохоор заасан.
- ♦ Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь нь хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулдаг бол тогтворжуулах гэрчилгээ авсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд татварын орчныг тогтворжуулна.
- ♦ Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуурыг Засгийн газар батална.

Хөрөнгө оруулалтын гэрээ

- ♦ 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуульд зааснаар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулдаг. Хуулийн төсөлд тус зохицуулалтыг хасаж оронд нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлтийг Засгийн газрын журамд заасан шаардлагад үндэслэн Засгийн газраас шийдвэрлэж байхаар тусгасан байна.
- ♦ Хөрөнгө оруулалтын гэрээгээр тогтворжуулах гэрчилгээний адилаар 4 төрлийн татварын орчныг тогтворжуулах боломжтой бөгөөд мөн л 30 хүртэлх жилийн хугацааг байгуулж болохоор заажээ.
- ♦ Мөн хөрөнгө оруулалтын гэрээнд татварын бус урамшууллыг олгох зохицуулалттай байна.
- ♦ Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад тавигдах шаардлага, хяналт тавихтай холбоотой журмыг Гадаадын Хөрөнгө Оруулалтын Зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн Засгийн газар батална.

4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХАМГААЛАЛТ

Энэхүү Хуулийн төсөл дэх хөрөнгө оруулалтын хамгаалалт, хөрөнгө оруулагчдад олгох баталгаатай холбоотой зохицуулалтууд 2013 оны Хөрөнгө оруулалтын тухай хуультай ерөнхийдөө төстэй байна. Энэ хүрээнд орсон зарим гол өөрчлөлтийг дурдвал:

- Гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн бизнесийн нууцыг хамгаалах зохицуулалт нэмэгдсэн.
- Үндэсний болон нийтийн эрх ашгийн үүднээс гэрээ, гэрчилгээний нөхцөлийг өөрчлөх бол хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд учирсан хохирлыг хуульд заасны дагуу нөхөн төлнө.
- Хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдлыг дордуулах аливаа шийдвэр гаргахыг хориглосон.

5. БУСАД ӨӨРЧЛӨЛТҮҮД

Хуулийн төсөлтэй холбогдуулан мөн төрийн хяналт шалгалт, бүртгэл зэрэгтэй холбоотой дараах зохицуулалтыг өөрчлөгдөхөөр байна.

Төрийн хяналт шалгалт	Дотоодын хувьцаа эзэмшигчийн шаардлага	Улсын бүртгэл
Хуульд зааснаас бусад тохиолдолд гадаадын хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо жилд хоёроос ихгүй байхаар зохицуулсан.	Аудитын тухай хууль, Үнэлгээний тухай хууль, Усны тухай хууль зэрэгт тусгасан “дотоодын хувьцаа эзэмшигчтэй” байх шаардлагыг үгүй болгосон.	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд ялгамжтай тогтоосон улсын бүртгэлийн хугацаа болон тэмдэгтийн хураамжийн хэмжээг дотоодын хуулийн этгээдтэй адил байхаар бууруулсан.



Бидэнтэй холбогдоорой!

Та Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд болон бусад асуудлаар хууль зүйн зөвлөгөө авахыг хүсвэл бидэнтэй холбогдоно уу.



PwC Legal
A multidisciplinary law firm

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Лерал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Бид энэхүү нийтлэлд үндэслэн хийсэн аливаа үйлдэл, эс үйлдэхүйн хувьд хариуцлага хүлээхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Лерал ХХН-ийг илэрхийлнэ.